

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) нь улс орны эдийн засгийн үйл ажиллагааны цар хэмжээг харуулдаг макро эдийн засгийн чухал үзүүлэлт юм. ДНБ-ий үйлдвэрлэлийн аргын тооцоо нь эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хийгддэг ба эдгээр эдийн засгийн салбарын үйл ажиллагаа нь ДНБ-д ямар хувь нэмэр оруулж байгааг харуулдаг. Мөн эдийн засгийн бодит өсөлтийг үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан буюу зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий өөрчлөлтөөр тодорхойлдог. 2018 онд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг өмнөх оныхоос 21.1 хувь, үйлдвэрлэлийн салбарынх 16.1 хувь, үйлчилгээний салбарынх 4.9 хувиар тус тус нэмэгдсэн байна. Хувийн хэвшилд бий болсон нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2017 онд 76.5 хувь байсан бол 2018 онд 78.4 хувь болж 1.9 пунктээр нэмэгдсэн байна.



Дотоодын нийт бүтээгдэхүүн 2018 он /салбар/

